

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН
ТАЛААРХ АЖЛЫН ХЭСГИЙН ТАЙЛАН**

Товч удирдамж: Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам /цаашид "журам" гэх/-ын 12.1, 12.2, 12.3, 12.4-т заасны дагуу Ажлын хэсэг нь олонхын саналаараа Улсын Их Хуралд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийн талаарх тайланг энэхүү загварт нийцүүлэн бичих үүрэгтэй. Журмын 13.1-д заасны дагуу Ажлын хэсгийн тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах тул уг тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хувь хүний нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Наранчулуун Ургийн овог: Халиугчин Нэр: Отгончимэг Хүйс: Эмэгтэй Төрсөн он: 1976 Төрсөн газар: Хөвсгөл аймаг, Мөрөн сум Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний алинд нэр дэвших тухай хүсэл гаргасан талаар бичнэ. <i>Нэр дэвшигч Н.Отгончимэг нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших хүсэлт гаргасан.</i>
Сонгон шалгаруулалт, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга	
Сонгон шалгаруулалтын найман үе шат тус бүрийг журмын Дөрөв, Тав, Зургаа, Долоо, Найм, Ес, Арав, Арван нэг, Арван хоёрт заасны дагуу хэрхэн хэрэгжүүлсэн талаар тодорхой, ойлгомжтой бичнэ.	
3	Нэгдүгээр үе шат Журмын 3.1.1-д заасны дагуу "сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх" үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ. <i>Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 5 гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус 5 гишүүнийг Монгол Улсын Их Хурлаас нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулж томилохоор заасны дагуу 2021 оны 03</i>

	<p>дугаар сарын 10-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 17 цаг 30 минут хүртэл олон нийтэд нээлттэй зарлаж, холбогдох материалыг хүлээн авахаар Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолыг баталсан.</p> <p>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалтын зарыг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд нийтэд мэдээлсэн.</p>
4	<p>Хоёрдугаар үе шат Журмын 3.1.2-д заасны дагуу “нэр дэвших тухай хүсэлт гаргах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар тогтоолоор сонгон шалгаруулалтын бүртгэлийн хугацааг тогтоож, хүсэлт, материалыг 21 хоногийн хугацаанд хүлээн авахаар нийтэд мэдээлсэн бөгөөд тус хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нийт 59 хүн нэрээ дэвшүүлэн, холбогдох материалыг ирүүлснээс 1 хүн нэрээ татаж нийт 58 хүн нэр дэвших хүсэлт гаргасан.</p>
5	<p>Гуравдугаар үе шат Журмын 3.1.3-д заасны дагуу “Ажлын хэсэг байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 09, 10, 20 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн даргын зөвлөх Д.Батдорж, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монголын Өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч М.Баасанбат, Монголын Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн М.Мөнхбат, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн танхимын багш доктор, профессор О.Мөнхсайхан, “Шихихутуг” их сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч Г.Амаржаргалан нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.</p> <p>Тайлбар: Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор Сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. Монголын Хуульчдын холбооны төлөөллийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бөгөөд Монголын Хуульчдын холбооноос Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн М.Мөнхбатын нэрийг ирүүлсэн тул Хууль зүйн байнгын хорооны 09 дүгээр тогтоолд нэмэлт оруулах тухай 10 дугаар тогтоолыг баталсан. Түүнчлэн Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга А.Бямбажаргалын албан үүрэг өөрчлөгдсөн тул Хууль зүйн байнгын хорооны 09 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай 20 дугаар тогтоолоор ажлын хэсгийн</p>

	<i>бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан.</i>
6	<p>Дөрөвдүгээр үе шат Журмын 3.1.4-д заасны дагуу “нэр дэвшигчээр бүртгэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p><i>Ажлын хэсэг 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хуралдаж Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль болон Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-д заасан материалын шаардлагыг хангасан гэж үзэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд 29 хүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд 24 хүнийг нэр дэвшигчээр бүртгэсэн.</i> <i>Ажлын хэсгийн энэхүү хуралдаанаар Н.Отгончимэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчээр бүртгэсэн.</i></p>
7	<p>Тавдугаар үе шат Журмын 3.1.5-д заасны дагуу “нэр дэвшигчийн баримт бичгийг цахим хуудаст байршуулах, асуулт, санал хүлээн авах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p><i>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 8.1-д “нэр дэвшигчээр бүртгэснээс хойш ажлын нэг өдрийн дотор бүртгэсэн нэр дэвшигчдийн нэрс, нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж түгээнэ.” гэж заасны дагуу дээр дурдсан 53 нэр дэвшигчийн материалыг www.parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан.</i> <i>Н.Отгончимэгийн Нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн байршуулсан.</i></p>
8	<p>Зургадугаар үе шат Журмын 3.1.6-д заасны дагуу “нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p><i>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 10.1-д “Энэ журмын 9.1-д заасны дагуу бүртгэсэн шийдвэр гармагц Ажлын хэсэг нэр дэвшигчийг Ажлын хэсгийн ахлагчаас бусад гишүүн бүрд тохиолдлын журмаар тэнцвэртэй хуваарилж илтгэгч гишүүнийг томилно” гэж заасныг баримтлан 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Ажлын хэсгийн хуралдаанаар нэр дэвшигч тус бүрийн илтгэгч гишүүнийг сугалаагаар тодруулж, илтгэгч гишүүнийг томилсон.</i></p>
9	<p>Долдугаар үе шат Журмын 3.1.7-д заасны дагуу “Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p><i>Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 10-ны</i></p>

	<p>өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 11.1-д “Энэ журмын 10.7-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигч нь холбогдох шаардлагыг хангасан эсэхийг тодруулах зорилгоор Ажлын хэсэг нэр дэвшигч тус бүртэй ярилцлага зохион байгуулна.” гэж, 11.2-д “Ажлын хэсэг зургаагаас доошгүй тооны гишүүний ирцтэйгээр ярилцлага хийх бөгөөд Ажлын хэсгийн ахлагч даргална.” гэж заасан.</p> <p>Ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 8,9,10-ны өдрүүдэд ажлын хэсгийн ярилцлагыг зохион байгуулсан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд 29 хүн нэр дэвшсэнээс 3 хүн нэрээ татсан бол 1 хүний төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн, 1 хүн ярилцлагад ороогүй тул бүртгэлээс хасаж нийт 24 хүнтэй ярилцлага зохион байгуулсан. Шүүхийн сахилгын хороонд 24 хүн нэр дэвшсэнээс 1 хүн нэрээ татсан тул 23 хүнтэй ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулсан.</p>
<p>10</p>	<p>Наймдугаар үе шат Журмын 3.1.8-д заасны дагуу “нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгох” үе шат хэрхэн хэрэгжсэн талаарх мэдээлэл, үндэслэл бүхий дүгнэлт бичнэ.</p> <p>“Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 12.1-д “Энэ журмын 11.6-д заасан хугацаа дууссанаас хойш ажлын дөрвөн өдрийн дотор Ажлын хэсэг дараах журмаар хуралдаж Ерөнхий зөвлөлийн эсхүл Сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.” гэж, мөн журмын 12.6-д “Энэ журмын 12.1-д заасан хуралдаанаас хойш ажлын гурван өдрийн дотор энэ журамд заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ.” гэж заасны дагуу саналаа Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх зохицуулалттай.</p> <p>Ажлын хэсэг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4.5- “энэ хуулийн 77.4.4-т заасан санал хураалтын дүнгээр Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэл хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд тайлангийн хамт ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх.” гэж заасан. Ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж, илтгэгч гишүүн бүр өөрсдийн судалсан нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг танилцуулж, ажлын хэсгийн бусад гишүүн саналаа хэлж, асуулт асууж хэлэлцсэн. Үүний дараагаар санал хураалтыг нууцаар явуулахад зургаан нэр дэвшигч Ажлын хэсгийн гишүүдийн олонхын саналыг авсан. Өөрөөр хэлбэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Н.Отгончимэг 9 санал, Д.Эрдэнэчимэг 8 санал, Н.Баасанжав 7 санал, Р.Онончимэг 7 санал, Д.Зүмбэрэллхам 6 санал, Н.Мөнгөнцэцэг 6 санал тус тус авсан.</p>
<p>11</p>	<p>Сонгон шалгаруулалтын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь Ажлын хэсэг журмын 7.1-д заасан бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлсэн бэ, мөн журмын 12.4.1-д заасны дагуу сонгон шалгаруулалт нь Шүүхийн тухай хууль болон энэ журмын дагуу явагдсан тухай нэгтгэн дүгнэж бичнэ. Монгол Улсын Шүүхийн тухай хууль болон Хууль зүйн байнгын хорооны</p>

	<p>2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.</p> <p>Ажлын хэсэг нь сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын хүрээнд зохион байгуулсан бөгөөд аливаа нөлөөлөлд авталгүй хууль, журмыг дээдлэн ажилласан болно.</p>
<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хангасан тухай үнэлгээ</p>	
<p>Нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, нэр дэвшигчийн хэвлүүлсэн бүтээл, олон нийтэд өгсөн мэдээлэл, олон нийтээс ирүүлсэн асуулт, санал, нэр дэвшигчийн талаар бусад хүмүүстэй хийсэн ярилцлага, нэр дэвшигчтэй илтгэгч гишүүний ганцаарчлан хийсэн ярилцлага, Ажлын хэсгийн ярилцлага, илтгэгч гишүүний дэлгэрэнгүй тайлан, нэр дэвшигчээс болон бусад этгээдээс гаргуулан авах зэргээр цуглуулсан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтад тулгуурлан нэр дэвшигчид тавих шаардлагыг яагаад хамгийн сайн хангасан гэж үнэлж дүгнэсэн тухайгаа журмын 12.4.3-т заасны дагуу ойлгомжтой, тодорхой бичнэ.</p>	
<p>12</p>	<p>Боловсрол</p> <p>Төгссөн их, дээд сургууль, коллеж, боловсролын зэрэг, төгссөн оноор нь хамгийн сүүлийнхээс нь эхлэн дараалуулж жагсааж, журмын 2.1.2, 2.2.2-д заасан шаардлагыг хангаж байгаа нь ямар мэдээлэл, нотлох баримтаар тогтоогдсон талаар бичнэ.</p> <p>2012 он <i>King’s College London (Кингс Коллеж Лондон), хууль зүйн магистр /LLM/</i></p> <p>2001 он <i>Екатеринбург, ОХУ, Уралын Их Сургууль, хүний эрхийн курс</i></p> <p>1999 он <i>МУИС-ийн магистрантур, магистр /МА/</i></p> <p>1998 он <i>МУИС-ийн Хууль зүйн сургууль, эрх зүйч /бакалавр/</i></p> <p><i>Н.Отгончимэг нь эрх зүйч мэргэжил эзэмшсэн, хууль зүйн магистрын зэрэгтэй болох нь дипломын хуулбаруудаар нотлогдож байна.</i></p>
<p>13</p>	<p>Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан тухай</p> <p>Журмын 2.1.2, 2.2.2-д заасны дагуу эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</p> <p><i>Н.Отгончимэг нь эрх зүйч мэргэжлээр нийт 22 жил ажиллаж дээрх шаардлагыг хангасан болно. Энэ нь дараах баримтаар нотлогдож байна:</i></p> <ol style="list-style-type: none"> 1. <i>Захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа хариуцсан зөвлөх, Улсын дээд шүүхийн Тамгын газар, 2020.10 сараас.</i> 2. <i>“Эрүүл мэндийн санхүүжилтийг сайжруулах төсөл”-ийн Зөвлөх, Сангийн яам, 2020.1.27-2020.9.20.</i> 3. <i>Зөвлөх, “Эрдэнэс Монгол” ХХК, 2020.1.14 - 2021.1.14</i> 4. <i>“Чадавхыг бэхжүүлэх техникийн туслалцаа үзүүлэх төсөл”-ийн Зөвлөх, Сангийн яам, 2016.5.16-2016.8.30, 2017.10.30-2018.1.31</i>

	<p>5. “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн Зохицуулагч, УИХ-ын Тамгын газар, 2016.1-2017.1 сар</p> <p>6. УИХ-ын Тамгын газрын Нэгдүгээр орлогч (Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга), 2013.4.26-2015.12.31 са</p> <p>7. Хуулийн хэлтсийн дарга, “Эрдэнэс Таван Толгой” ХК, 2012.8.1-2012.11.19 сар:</p> <p>8. Хуулийн асуудал эрхэлсэн захирал, “Сүри Менежмент” ХХК, 2007.01.02-2012.08.01</p> <p>9. Хуулийн асуудал эрхэлсэн захирал, “ГКЭ” ХХК, 2005.6.1-2007.01.02</p> <p>10. Эрдэм шинжилгээний ажилтан, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2003.04.01-2005.06.01</p> <p>11. Эрх зүйн багш, “Халх Журам” ХЗДС, “Сүлд” коллеж, 1998.9-2003.2 сар</p>
14	<p>Хууль зүйн өндөр мэргэшилтэй: хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай тухай</p> <p>Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</p> <p>Нэр дэвшигч Н.Отгончимэгийг дараах үндэслэлээр “Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай” гэж үзэж байна. Үүнд:</p> <p>2021 он: Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал. “Нийт шүүх, шүүгчийг сургалт, судалгаа, мэдээллээр хангах чиг үүрэгтэй.”</p> <p>2020 он: Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа хариуцсан зөвлөх. “Эрүүл мэндийн санхүүжилтийг сайжруулах төсөл”-ийн Зөвлөх, Сангийн яам. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Эрүүл мэндийн даатгалын тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн тухай зэрэг хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулахад оролцож, хууль зүйн техникийн асуудлаар зөвлөгөө өгөв. Лавлагаа шатлалын гурван эмнэлгийн хагас бие даасан байдлын шинэчлэлийн хүрээнд эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан болон хуульд заасны дагуу тэдгээр эмнэлгийн гүйцэтгэх захирлыг ТУЗ сонгон шалгаруулахад хууль зүйн зөвлөгөө, эрх зүйн баримт бичгийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. https://www.legalinfo.mn/additional/details/3861?lawid=10922 https://www.legalinfo.mn/additional/details/3863?lawid=11929 https://www.legalinfo.mn/additional/details/3862?lawid=49</p> <p>2019-2020 он: Зөвлөхийн ажил үүрэг, “Эрдэнэс Монгол” ХХК: “Ирээдүйн өв</p>

сангийн тухай хуулийн зохицуулалтын дүн шинжилгээ” хийв. Үндэсний баялгийн сангийн хуулийн төслийн үзэл баримтлал, төслийг боловсруулахад оролцсон.

2019 он: “Засгийн газар хариуцагчаар оролцсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүдийн дүн шинжилгээ” ажлыг хийсэн.

http://forum.mn/res_mat/2020/Shuuhinshiidveriinanalize3.pdf

“Герман, Орос, Австри, Латви, Солонгос улсын Үндсэн хуулийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа: харьцуулсан судалгаа” хийсэн. <https://legaldata.mn/b/696>

“Герман, Орос, Австри, Латви, Солонгос улсын Үндсэн хуулийн шүүх: харьцуулсан судалгаа” хийсэн. <https://legaldata.mn/b/695>

2018 он: “Монгол Улсын хуулиуд дахь иргэний оролцооны талаарх зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ”

/Судалгааны багийн ахлагч/ <http://oroltsoo.mn/file/8.pdf>

2017 он: “Гадаадын зээл, тусламжийн удирдлагын эрх зүйн зохицуулалтын дүн шинжилгээ” <https://legaldata.mn/b/694>

Зөвлөхийн ажлыг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын “Чадавхыг бэхжүүлэх техникийн туслалцаа үзүүлэх төсөл”-ийн захиалгаар гүйцэтгэсэн байна.

2013-2016: УИХ-ын Тамгын газрын Нэгдүгээр орлогч (Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга)-ын ажил үүргийг гүйцэтгэв.

- Чуулганы нэгдсэн хуралдаанд дэгийн асуудлаар зөвлөгөө өгөх, гишүүдэд лавлагаа өгөх, өргөн мэдүүлэхээр ирүүлсэн хууль, тогтоолын төсөл хуульд заасан бүрдлийг хангасан эсэхэд хяналт тавих, УИХ-ын 7 хоногийн хэлэлцэх асуудлын хуваарийн төслийг бэлтгэх ажилд хяналт тавих, хууль, тогтоолын төсөл боловсруулахад гишүүдэд арга зүйн туслалцаа үзүүлэх, баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг хянахад санал өгөх, хууль, тогтоолын хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт тавих, УИХ-ын гишүүдийн захиалгаар судалгаа, мэдээлэл бэлтгэх ажилд хяналт тавих, чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны хуралдааныг зохион байгуулахад хяналт тавих зэрэг ажил үүргийг гүйцэтгэсэн.

- Үндсэн хуулийн эхийг баригч, нэрт хуульч Б.Чимидийн нэрэмжит шагнал бий болгох журмын төслийг боловсруулсан. Уг журмын төслийг УИХ-ын даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэж УИХ-ын даргын 2015 оны 176 тоот захирамжаар баталсан. Энэхүү журам батлагдсанаар Монгол төрийн нэрт зүтгэлтэн Ардчилсан шинэ Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч Баяраагийн Чимидийн Монгол төрд зүтгэсэн гавьяа зүтгэлийг мөнхжүүлэх, судалгаа шинжилгээнд суурилсан хууль тогтоох ажиллагааг хөгжүүлэх, парламент судлал, үндсэн хуулийн эрх зүй, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр гарсан үнэ цэнэтэй томоохон бүтээлийг хөхүүлэн дэмжих, энэ чиглэлийн эрдэм судлалын ажилд оюун ухаанаа зориулах эрдэмтэн, судлаачдын тоог нэмэгдүүлэх зорилготой байсан.

2009 он: Тавантолгой төслийн хөрөнгө оруулалтын болон хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөл боловсруулах ажилд тусалж зөвлөгөө өгөх, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий хуульч-мэргэжилтний багийн гишүүнээр ажилласан.

	<p>Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009-7-3-ны өдрийн 159 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллав.</p> <p>2005 он: Захиргааны хэргийг иргэний хэргээс ялгах аргачлалын талаар судалгаа хийж “Захиргааны хэргийн харьяалал” ном гаргасан байна.</p>
15	<p>Хууль зүйн өндөр мэргэшилтэй: мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлага хангасан тухай</p> <p>Нэр дэвшигч нь журмын 2.1.1, 2.2.1-д заасан шаардлагын хүрээнд “бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар ажиллах, зарчимч, шударга зан төлөвтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлагыг хангасан” гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр ойлгомжтой, тодорхой бичнэ.</p> <p><i>Нэр дэвшигч Н.Отгончимэг нь бусдын нөлөөнд автахгүй, хараат бусаар ажиллах, зарчимч, шударга зан төлөвтэй, мэргэжлийн ёс зүйн өндөр шаардлагыг хангасан гэж дүгнэж байна. Тухайлбал:</i></p> <p>- Нэр дэвшигч Н.Отгончимэг нь эрх зүйч мэргэжлээр 22 жил ажиллахдаа судалгаа, эрдэм шинжилгээний ажилд багагүй хугацаа зарцуулсан байна. Ажлын энэ туршлага нь аливаа асуудалд судалгаатай, үндэслэлтэй хандах зан төлөв, хандлага тогтоосон байх үндэстэй. Түүний гүйцэтгэсэн судалгаа, бүтээлээс үзэхэд асуудлыг тал бүрээс нь авч үзэж, дүгнэх чадвар эзэмшсэн, хэт туйлширах үзэлгүй, бичгийн чадвар өндөр түвшинд эзэмшсэн байна.</p> <p>- Түүнийг мэдэх хүмүүстэй хийсэн ярилцлагад Н.Отгончимэгийг зарчимч, шударга зан төлөвтэй, хамт ажиллахад яриа нь маш цэгцтэй, илүү дутуу үг хэрэглэлгүй ярьдаг, хуульч мэргэжлийн нарийн төвөгтэй асуудлыг маш сайн ойлгосон, хууль боловсруулах техник, туршлага маш өндөр төвшний хуульч хэмээн тодорхойлсон байна.</p> <p>- Ажил байдлын тодорхойлолтод: “Иргэдийн оролцоотой хууль тогтоох үйл ажиллагааг дэмжих төсөл” нь УИХ-ын Тамгын газрын дэргэд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжсэн бөгөөд Н.Отгончимэг нь тус төслийн зохицуулагчаар ажилласан. Тэрээр тус ажил үүргийг гүйцэтгэх явцдаа төслийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон оролцогч талуудын уялдаа холбоо, зөвшилцлийг хангаж ажиллаж байв.”, мөн “Судлаач хүний хувьд маш хөдөлмөрч, аливаа асуудалд нухацтай ханддаг зан байдал нь Н.Отгончимэгийн үнэлүүштэй чанарын нэг бөгөөд зан төлөв, ёс зүй, бусадтай харилцах байдлаараа хуульчийн нэр хүндийн шалгуурыг хангаж яваа” гэж тодорхойлсон.</p> <p>- Нэр дэвшигч Н.Отгончимэг ажлын хэсгийн ярилцлагад амжилттай оролцож мэргэжлийн өндөр түвшний хариулт өгч, дараах байдлаар байр сууриа илэрхийлсэн:</p> <p>“Шүүн таслах ажиллагааны чанар нь иргэдийн шүүхэд итгэх итгэлтэй шууд хамаардаг, иргэдийн шүүхэд итгэх итгэл санасан хэмжээнд биш байгаа. Энэ шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлэхийн тулд бид нар шүүн таслах ажиллагааныхаа чанар гэдэг зүйлийг тодорхойлж хэмжих хэмжүүр, шалгууртай болох ёстой юм байна лээ.</p> <p>Мөн шүүх эрх мэдлийн хараат бус байдалд санаатай болон санаандгүйгээр, мэдлэг мэдээлэлгүйгээс болоод халдах тохиолдол</p>

	<p><i>байдаг. Үүний эсрэг бид илүү нээлттэй байх зарчим баримталж ажиллах хэрэгтэй гэж хувь судлаачийн үүднээс харж байна.</i></p> <p><i>Хууль батлагдсанаас хойш бас нэлээдгүй хэрэглэж байна, бүхэлд нь базаад хэлэхэд өмнөх хуулиас ололттой тал байна гэж харсан. Энэ бол шүүхийн дотоод ардчиллыг их сайхан дэмжээд гаргаад ирсэн юм болов уу үзэл баримтлалын хувьд. Нэгдүгээрт шүүгчдийн чуулганаа хэлэх байх, түүнээс гадна шүүгчдийн зөвлөгөөнд эрх мэдэл өгсөн, үүнийг зөв хэрэглэвэл их аятайхан болох байх гэж би бодож байгаа. Сул тал гэвэл хуулийн техниктэй их ойр ажилладаг байсан хүний хувьд тэр талыг нь жаахан харах юм. Гэхдээ хуулийг хэрэглэж байж л дараагийн зүйлийг ярих хэрэгтэй шүү дээ...” гэжээ.</i></p>
16	<p>Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй тухай Журмын 2.1.3, 2.2.3-д заасны дагуу “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй” байх шаардлагыг хангаж байгааг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Н.Отгончимэг 1976 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр төрсөн, 45 настай. Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй.</i></p>
17	<p>Монгол Улсын иргэн мөн тухай Журмын 2.1, 2.2-д заасны дагуу “Монгол Улсын иргэн” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Н.Отгончимэг Монгол Улсын иргэн мөн.</i></p>
18	<p>Сүүлийн таван жилд улс төрийн болон намын удирдах албан тушаал хашиж байгаагүй тухай Журмын 2.1.5, 2.2.4-д заасны дагуу “сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Н.Отгончимэг сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоор нотлогдож байна.</i></p>
19	<p>Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай Журмын 2.1.6, 2.2.10-д заасны дагуу “эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй” байх шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Н.Отгончимэг эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй нь ял шийтгэлгүй талаарх тодорхойлолтоор нотлогдож байна.</i></p>
20	<p>Сахилгын шийтгэлээр халагдаж эсхүл огцорч байсан эсэх тухай Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэхийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Н.Отгончимэг сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байгаагүй бөгөөд энэ нь нийгмийн даатгалын дэвтрээр нотлогдож байна.</i></p>

21	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай Журмын 2.2.6, 2.3-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй буюу ажиллаж байгаагүй, Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Н.Отгончимэг нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй, мөн ажиллаж байгаагүй бөгөөд энэ нь нийгмийн даатгалын дэвтрээр нотлогдож байна.</i></p>
22	<p>Шүүгчээр ажиллаж байгаагүй тухай Журмын 2.1.4, 2.2.4, 2.2.5-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч сүүлийн таван жил шүүгчээр ажиллаж байгаагүй байх, Шүүхийн сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчээр ажиллаж байгаагүй байх шаардлагатай. Энэхүү шаардлагыг хангаж байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Н.Отгончимэг нь шүүгчээр ажиллаагүй, мөн ажиллаж байгаагүй бөгөөд энэ нь нийгмийн даатгалын дэвтрээр нотлогдож байна.</i></p>
23	<p>Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй тухай Шүүхийн тухай хуулийн 95.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, ажиллаж байгаагүй гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Н.Отгончимэг нь Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр ажиллаагүй, мөн ажиллаж байгаагүй бөгөөд энэ нь нийгмийн даатгалын дэвтрээр нотлогдож байна.</i></p>
24	<p>Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа тухай Журмын 2.2.7-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь Шүүхийн захиргааны байгууллагын ажилтнаар ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Хамааралгүй</i></p>
25	<p>Өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа тухай Журмын 2.2.8-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь өмгөөлөгчөөр ажиллахгүй байгаа гэдгийг ямар мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Хамааралгүй</i></p>
26	<p>Прокуророор ажиллахгүй байгаа тухай Журмын 2.2.9-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигч нь прокуророор ажиллахгүй байгаа гэдгийг ямар</p>

	мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан дүгнэж буйгаа үндэслэлтэйгээр тодорхой, ойлгомжтой бичнэ.
	<i>Хамааралгүй</i>
27	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд санал болгох үндэслэлүүдийг нэгтгэн дүгнэх нь</p> <p>Ажлын хэсэг нь цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэлд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, ёс зүй, зан төлөвийг үнэлж журмын 2.1, 2.2, 2.3-д заасан харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хамгийн сайн хангаж буй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ.</p> <p><i>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Н.Отгончимэг нь эрх зүйч мэргэжлээр 22 жил ажилласан. Эрх зүйн судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагад төдийгүй хууль тогтоох, шүүх эрх мэдлийн төрийн дээд байгууллагад хууль зүйн мэргэжил, арга зүйн туслалцаа, зөвлөгөө өгөн ажиллаж байсан арвин туршлагатай. Судалгаа, эрдэм шинжилгээний 30-аад бүтээлтэй, эрх зүйн асуудлыг шинжлэн дүгнэх өндөр чадвартай. Н.Отгончимэг МУИС-ийн ХЗС-ийг эрх зүйч мэргэжлээр төгсөн, магистр, улмаар дэлхийд эхний 20-д эрэмбэлэгдэх Английн Кингс Коллежид магистр хамгаалж, мөн ОХУ-ын Уралын Их Сургуульд мэргэжил мэдлэгээ дээшлүүлж байснаас үзвэл өөрийн мэдлэг, боловсролоо байнга дээшлүүлж ирсэн хөдөлмөрч зан чанартай хуульч байна.</i></p> <p><i>Түүнчлэн захиргааны хэргийн шүүх байгуулахад судалгаа, сургалтын чиглэлээр оролцон ажиллаж байсан, мөн шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн чиглэлээр ажиллаж байгаа туршлагатай.</i></p> <p><i>Н.Отгончимэгийн удирдлагаар болон хамтран ажиллаж байсан хүмүүс нь ёс зүй, зан төлөвийг нь зарчимч, шударга гэж нийтлэг байдлаар давтан тодорхойлсон.</i></p> <p><i>Иймд холбогдох хууль, журамд заасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд тавигдах шаардлагыг бүрэн хангаж байна.</i></p>

Ажлын хэсгийн гишүүд

	Эцэг/эхийн нэр, өөрийн нэр	Гарын үсэг	Огноо
1			
2			
3			
4			
5			
6			

7			
8			
9			
10			
11			

Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг

2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

Хавсралт: тайлан гаргахад тулгуурласан баримт

1. Нэр дэвших тухай хүсэлт, түүний хүсэлт, 2021.03.31;
2. Төрийн албан хаагчийн анкет;
3. Иргэний үнэмлэхийн хуулбар;
4. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
5. Эрх зүйн бакалаврын зэргийн дипломын хуулбар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, 1998.06.12;
6. Хууль зүйн магистрын дипломын хуулбар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, 2000.01.18;
7. *Екатеринбург, ОХУ, Уралын Их Сургууль, хүний эрхийн курс, хуулбар, 2001*
8. *King's College London (Кингс Коллеж Лондон), хууль зүйн магистр /LLM/, хуулбар, 2012.08.01;*
9. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, 2014.07.07, №3650;
10. Хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэх тухай Хууль зүйн сайдын А/163 дугаар тушаалын хуулбар, 2013.07.22;
11. Эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримтын товъёог, 20 хуудас;
12. Хууль зүйн өндөр мэргэшилтэй тухай баримтын товъёог, 6 хуудас;
13. Ажил байдлын тодорхойлолтууд, 3 хуудас;
14. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай болон эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт;
15. Холбогдох бусад материал.

--- оОо ---

